



**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО
НИЙТИЙН ЭРХ ЗҮЙН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 3/30/26

Улаанбаатар хот

Үүрэг болгох тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дахь хэсэг, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дүрмийн 28 дугаар зүйлийн 28.1.11 дэхь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Засгийн Газрын 2025 оны 255 дугаар “Аялал жуулчлалын салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох тухай” тогтоолын хүрээнд арилжааны банкаар дамжиж олгогдож буй зээлийн талаарх мэдээллийг нягтлан, зээл олголтын хяналтыг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг заасан хугацаанд авч хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал (М.Нарангэрэл)-д тус тус үүрэг болгосугай.
 - a. Аялал жуулчлалын салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээлийн хүрээнд үүсэж буй асуудлыг нээлттэй ярилцах, үүссэн асуудлыг шийдвэрлэх арга замыг ирэлхийлэх, цаашид зээл олголт дахь хяналтыг сайжруулах тал дээр хамтран ажиллах талаар Соёл, Спорт, Аялал жуулчлал, Залуучуудын сайд Ж.Алдаржавхлантай уузалт зохион байгуулж, гишүүн байгууллагуудаас ирсэн саналыг багцлан хамтран ажиллах тухай албан бичгийг хүргүүлэх,
 - b. Соёл, Спорт, Аялал жуулчлал, Залуучуудын сайд Ж.Алдаржавхлан дээрх албан бичигт ажлын 5 хоногийн дотор хариу өгөөгүй тохиолдолд энэ талаар Монгол Улсын Ерөнхий Сайд Н.Учралд дээрх агуулга бүхий албан бичгийг хүргүүлэх,
 - c. Монгол Улсын Ерөнхий Сайд Н.Учрал дээрх албан бичигт ажлын 5 хоногийн дотор хариу өгөөгүй тохиолдолд энэ талаар Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороонд дээрх агуулга бүхий албан бичгийг хүргүүлэх,
2. Энэхүү тогтоолын дагуу авсан арга хэмжээний тухай мэдээллийг тухай бүр Удирдах зөвлөлд мэдээллэж байхыг Гүйцэтгэх захирал (М.Нарангэрэл)-д үүрэг болгосугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ

ЭТЭНГИСБОЛД

